

**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД**



**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРАЛ, ТҮҮНИЙ ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
2013 ОНЫ IV УЛИРЛЫН  
ТОГТООЛЫН ЭМХТГЭЛ**

2013 он



## АГУУЛГА

№	Тогтоолын тэргүү	Огноо, дугаар	Хуудасны дугаар
1	Аж ахуйн нэгж байгууллагуудыг камержуулах тухай	2013.10.15 №148	4
2	Төсөвт тодотгол хийх тухай	2013.11.06 №5/1	5
3	Ажлын хэсэг томилох тухай	2013.11.06 №5/2	9
4	Ажлын хэсэг томилох тухай	2013.12.19 №164	10
5	Төсөвт тодотгол хийх тухай	2013.12.26 №7/1	11
6	Ажлын тайлангийн тухай	2013.12.26 №7/3	13
7	Хяналт шалгалтын мөрөөр зохиох ажлыг сайжруулах тухай	2013.12.26 №7/4	15
8	Тайлангийн тухай	2013.12.26 №7/5	16
9	Тайлангийн тухай	2013.12.30 №171	18
10	Ажлын хэсэг томилох тухай	2013.12.30 №172	19





**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 10 сарын 15 өдөр

Дугаар 148

Номгон

**Аж ахуйн нэгж байгууллагуудыг  
камержуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-т заасныг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн амар тайван амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэх, өмч хөрөнгийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэрэг зөрчлийг цаг алдалгүй шуурхай илрүүлэх, таслан зогсоох зорилгоор Баянхонгор сумын захууд, худалдааны төвүүд, томоохон аж ахуйн нэгж, байгууллага, шатахуун түгээх станц, сургуулиудын нийтийн бие засах газар, банк бус санхүүгийн байгууллагуудыг камержуулахыг тухайн аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга, эрхлэгч, захирал нарт үүрэг болгосугай.

Хоёр. Хяналтын камерын чанар, стандарт шаардлагын талаар албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд чиглэл өгч ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга /Б.Оюутболд/-д даалгасугай.

Гурав. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д даалгасугай.

ДАРГА

Д.ШИРМЭН



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 11 сарын 06 өдөр

Дугаар 5/1

Номгон

**Төсөвт тодотгол хийх тухай**

Төсвийн тухай хуулийн 64.1.2 дахь заалт, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2-ын “б” заалт, Сангийн сайдын 2013 оны 05 сарын 24-ны өдрийн 4-1/2884 тоот зөвлөмж, 2013 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн Боловсролын салбарын 2013 оны урсгал зардлын талаарх зөвлөмжийг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын ээлжит бус V хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн 2013 оны төсвийн орлогыг 156107,1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт орлогыг 59620971,4 мянган төгрөгөөр баталсугай.

Хоёр. Аймгийн төсвийн татварын орлогыг дараах байдлаар өөрчилсүгэй.

№	Орлогын нэр төрөл	Дүн /мянган төгрөгөөр/
2.1	Цалин, түүнтэй адилтгах орлого	247607,1
2.2	Баян-Овоо сумын патентын орлогын төлөвлөгөө	60000,0
2.3	Шинэжинст сумын газрын төлбөрийн орлого	15000,0
2.4	Эрдэнэцогт сумын цалин, түүнтэй адилтгах орлого	-9000,0
2.5	Жаргалант сумын сумын цалин, түүнтэй адилтгах орлого	-14000,0
2.6	Бууцагаан сумын цалин, түүнтэй адилтгах орлого	-9000,0
2.7	Жинст сумын цалин, түүнтэй адилтгах орлого	-23500,0
2.8	Богд сумын цалин, түүнтэй адилтгах орлого	-15000,0
2.9	Баянговь сумын цалин, түүнтэй адилтгах орлого	-29000,0
2.10	Баянлиг сумын цалин, түүнтэй адилтгах орлого	-8000,0
2.11	Баянцагаан сумын цалин, түүнтэй адилтгах орлого	-25000,0
2.12	Баян-Өндөр сумын цалин, түүнтэй адилтгах орлого	12000,0
2.13	Заг сумын цалин, түүнтэй адилтгах орлого	-12000,0
2.14	Баацагаан сумын цалин, түүнтэй адилтгах орлого	-6000,0
2.15	Бөмбөгөр сумын цалин, түүнтэй адилтгах орлого	-2000,0

2.16	Баянбулаг сумын цалин, түүнтэй адилтгах орлого	-2000,0
	Нийт дүн	<b>156107,1</b>

Гурав. Аймгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг дараах байдлаар өөрчлөн баталсугай.

№	Сумын нэр	Дүн /мянган төгрөгөөр/
3.1	Баян-Овоо	-60000,0
3.2	Шинэжинст	-15000,0
3.3	Эрдэнэцогт	9000,0
3.4	Жаргалант	14000,0
3.5	Бууцагаан	9000,0
3.6	Жинст	23500,0
3.7	Богд	15000,0
3.8	Баянговь	29000,0
3.9	Баянлиг	8000,0
3.10	Баянцагаан	25000,0
3.11	Баян-Өндөр	12000,0
3.12	Заг	12000,0
3.13	Баацагаан	6000,0
3.14	Бөмбөгөр	2000,0
3.15	Баянбулаг	2000,0
	Нийт дүн	<b>91500,0</b>

Дөрөв. 2013 оны төсвийн орлогын нэмэгдүүлсэн 156107,1 мянган төгрөгийг дараах байдлаар хуваарилсугай.

№	Зардлын нэр төрөл	Дүн /мянган төгрөгөөр/
4.1	ХХААЖДҮГазар, ой тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны зардалд дэмжлэг	9000,0
4.2	Сумын ойгоо тэмдэглэсэн 4 сумд ойн арга хэмжээний зардлын дэмжлэг	20000,0
4.3	Байгаль орчны газрын автомашины үнийн зөрүү	10000,0
4.4	УБ хотод суух аймгийн төлөөлөгчийн цалин, үйл ажиллагааны зардал /11,12-р сар/	2000,0
4.5	Хангайн бүсийн хөгжлийн санд төвлөрүүлэх /Булган -2013 үзэсгэлэн худалдаа/	10000,0
4.6	Аймгийн ИТХ-ын намын суудлын мөнгө	2500,0
4.7	Аймгийн ИТХ-ын буцалтгүй тусламж, хүндэтгэлийн арга хэмжээ	2050,0
4.8	Хот тохижилтын төсвийн дэмжлэг	57708,0
4.9	Баянбулаг сумаас аймгийн ИТХ-ын төлөөлөгч сонгох нөхөн сонгуулийн зардал	4849,1

4.10	Баацагаан сумын харьяат Д.Ичинноровын Пауэрлифтингийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох зардал /Засаг даргын нөөц/	3000,0
4.11	Дэлхийн аварга М.Уранцэцэгт тэтгэмж өгөх /Засаг даргын нөөц/	35000,0
	Нийт дүн	<b>156107,1</b>

Тав. Аймгийн 2013 оны Орон нутгийн хөгжлийн санд төвлөрсөн хандив 315000,0 мянган төгрөг, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийн орлого 122793,1 мянган төгрөг, Орон нутгийн өмчийн албаны давсан орлого 18200,0 мянган төгрөг бүгд 455993,1 мянган төгрөгийг дараах байдлаар хуваарилсугай.

№	Зардлын нэр төрөл	Дүн /Мянган төгрөгөөр/
5.1	“Чандмань-Баянхонгор” ХК-д аймгийн төвийн цэвэр усны шугамын шинэчлэл	245731,4
5.2	Хөдөөгийн сумдын ундны усанд шинжилгээ хийлгэсэн зардал	30800,0
5.3	Аймгийн төвийн болон айлуудын хог цэвэрлэгээний зардал	19572,9
5.4	2-р цэцэрлэгийн халаалтын засвар зардлын дутагдал	2658,4
5.5	Баянбулаг сумын сургуулийн их засвар	80000,0
5.6	Хүрээмарал сумын Архигүй сум болох үйл ажиллагааг зохион байгуулах зардал, сургалт, Алтан бэрийн чуулга уулзалт	5300,0
5.7	ХДТ-ын урд цэцэрлэгт хүрээлэнгийн хашааны үнэ усалгааны холбох хэрэгслийн үнэ	9900,0
5.8	Баянхонгор сумын 2, 3-р багийн нутаг дэвсгэрт орших 15.17-р усан сангийн ус нөөцлөх савыг солих	7000,0
5.9	Хогын савны мөнгө /Эргэн төлөгдөхөөр/	10000,0
5.10	Жаргалант сумын эмнэлгийн халаалтын зуух солих	15000,0
5.11	Баянхонгор сумын “Оточ-номгон” өрхийн эмнэлэг, 6-р цэцэрлэгийн төвлөрсөн цэвэр усны шугамтай холбох гадна цэвэр усны шугам ажил	20030,4
5.12	Баянговь сумын орон нутгийн хөгжлийн санд	10000,0
	Нийт дүн	<b>455993,1</b>

Зургаа. Улсын нэгдсэн төсөвт тодотгол хийсэнтэй уялдуулж аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хэмжээг дараах хуваариар баталсугай.

№	Сумдын нэр	Тодотгосон төсөв /мянган төгрөгөөр/
6.1	Галуут	288089,5
6.2	Баян-Овоо	219261,3
6.3	Эрдэнэцогт	285396,7
6.4	Өлзийт	249091,5
6.5	Жинст	271738,5
6.6	Богд	283089,1
6.7	Баянлиг	336595,3

6.8	Баянговь	271536,5
6.9	Шинэжинст	408917,2
6.10	Баян-Өндөр	410708,1
6.11	Баянцагаан	317241,0
6.12	Баацагаан	325589,2
6.13	Бөмбөгөр	247085,1
6.14	Бууцагаан	302490,1
6.15	Хүрээмарал	294298,8
6.16	Баянбулаг	262283,2
6.17	Гурванбулаг	255285,6
6.18	Заг	256604,9
6.19	Жаргалант	253092,5
6.20	Баянхонгор	614248,8
6.21	Аймгийн ОНХС	4101769,7
	Нийт дүн	<b>10254413,6</b>

Долоо. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх дараах төсөл хөтөлбөрүүдэд зарцуулах 733006,0 мянган төгрөгийн төсвийг дараа онд шилжүүлэн эхний ээлжинд санхүүжүүлсүгэй.

№	Зардлын нэр төрөл	Дүн /мянган төгрөгөөр/
7.1	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөрөнгө оруулалт	475020,0
7.2	Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ	186986,0
7.3	Агаарын бохирдлыг бууруулах утаагүй зуух худалдан авах	57000,0
7.4	Хөдөлмөр эрхлэлтийн дэмжихэд	10000,0
7.5	Хоршоог дэмжихэд	4000,0

Найм. Энэ онд орон нутгийн хөгжлийн санд орохоор хүлээгдэж буй 150000,0 сая төгрөгийг өвөлжилтийн бэлтгэл хангах болон бусад шаардлагатай арга хэмжээг санхүүжүүлэх дарааллыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн энэхүү төсвийн зарцуулалтын тодотголыг 2013 онд багтаан ИТХ-д хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгасугай.

Ес. Орлогыг орлуулан тооцоолох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааг орон даяар явуулахаар шийдвэрлэсэн Монгол улсын Засгийн газрын 2013 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 269 дүгээр тогтоолыг дагуу нийгмийн халамжийн сангаас 247921,5 мянган төгрөгийг зарцуулахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д зөвшөөрсүгэй. Арав. Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжүүлэх байгууллагуудын төсвийн тодотголыг хавсралтаар баталсугай.

ДАРГА

Д.ШИРМЭН





**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 11 сарын 06 өдөр

Дугаар 5/2

Номгон

**Ажлын хэсэг томилох тухай**

Төсвийн тодотголын тухай асуудлыг аймгийн ИТХ-ын ээлжит бус Ү хуралдаанаар хэлэлцэхээр төлөөлөгчдөд тараах материалыг хуульд заасны дагуу 1 хоногийн өмнө тараасан байхад хуралдаан эхлэхийн өмнө аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсээс дахин өөрчлөлт оруулан тарааж улмаар 2013 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэн ээлжит бус хуралдаанд оруулахаар зөвшөөрсөн төсөлтэй зөрүүтэй байсан нь хуралдааны ажиллагаа хэвийн явагдах нөхцлийг алдагдуулж, хуралдааны бэлтгэл зохион байгуулалтын ажил ямар байгаа болон албан тушаалтнуудын хариуцлагагүй байдлыг илтгэн харуулсныг тэмдэглээд хурлын төлөөлөгчдөөс гаргасан санал шүүмжлэлийг үндэслэн аймгийн ИТХ-ын ээлжит бус Ү хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн ИТХ, түүний Тэргүүлэгчдээс батлан гаргасан тогтоол, шийдвэрийн хуульд нийцсэн эсэхэд дүгнэлт хийж, зөрчлийг арилгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Баатарсүх /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч/

Гишүүдэд: С.Готов /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч/

Г.Батжаргал /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч/

Ж.Дулмаа /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч/

Х.Батбаяр /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч/

Хоёр. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн дагуу хуралдааны бэлтгэлийг хангах ажлыг үр дүнтэй зохион байгуулж, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагуудын удирдлагыг нэгдсэн нэг ойлголттой болгоход анхаарч, ажлын уялдаа холбоог сайжруулж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /О.Тойвгоо/ нарт тус тус даалгасугай.

ДАРГА

Д.ШИРМЭН



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 164

Номгон

**Ажлын хэсэг томилох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх заалт, аймгийн ИТХ дахь МАН-ын бүлгийн хүсэлтийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн нийгэм, эдийн засгийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө болон ангилагдаагүй зардлын зарцуулалт, сумдын орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн зарцуулалт, үр дүнг шалгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Очирбал- /Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч/

Гишүүд:

С.Готов - /Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч/

Д.Хүрэлбаатар -/Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч/

Г.Батжаргал- /Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч/

Л.Ганхүү- /Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч/

Хоёр. Ажлын хэсэг /Ц.Очирбал/-д даалгах нь:

1. Аймгийн ИТХ дахь МАН-ын бүлгийн “2013 оны худалдан авах үйл ажиллагааны баримттай танилцаж дүгнэлт өгөх” хүсэлтийг Мерси Кор ОУБ-аас хэрэгжүүлж буй “Орон нутгийн хариуцлагатай засаглалын төлөөх идэвхтэй түншлэл ба иргэдийн оролцоо” төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлж буй иргэний нийгмийн байгууллагуудаар гүйцэтгүүлсүгэй.
2. Шалгалтын үр дүнг 2014 оны 2 дугаар сарын 25-ны дотор аймгийн ИТХ-ын хуралдаанд хэлэлцүүлж, олон нийтэд сурталчилж ажилласугай.

ДАРГА

Д.ШИРМЭН



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 7/1

Номгон

**Төсөвт тодотгол хийх тухай**

Төсвийн тухай хуулийн 64.1.2 дахь заалт, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын YII хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Орон нутгийн 2013 оны төсвийн орлогын төлөвлөгөөг 293308.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 5,380,404.6 мянган төгрөгөөр баталсугай.

Хоёр. 2013 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн тодотголоор орсон Баян-Овоо сумын патентын орлогын төлөвлөгөөг 60000,0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж мөн дүнгээр санхүүгийн дэмжлэгийг хасч тодотгосныг өөрчилж патентын орлогын төлөвлөгөөг 26284.1 мянган төгрөгөөр бууруулж мөн дүнгээр санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлж 149116.0 мянган төгрөгөөр баталсугай.

Гурав. Төсвийн орлогын төлөвлөгөө тасалдаж буй нэр бүхий сумдын орлогын төлөвлөгөөг дараах байдлаар бууруулж, санхүүгийн дэмжлэгийг мөн дүнгээр нэмэгдүүлж 2556369.9 мянган төгрөгөөр баталсугай.

№	Сумдын нэр	Санхүүгийн дэмжлэг нэмэх	Санхүүгийн дэмжлэг
1	Жаргалант	1715.2	193001.5
2	Баянлиг	1718.5	164344.3
3	Баянбулаг	2065.1	186761.5
4	Өлзийт	2588.1	191096.2
5	Гурванбулаг	2836	200209.4
6	Баянговь	2891.7	196632.9
7	Эрдэнэцогт	3671.7	204225.4
8	Баацагаан	3850.2	233394.5
9	Жинст	4876.4	224786.3
10	Бөмбөгөр	9225.7	182370.7
11	Богд	11435.9	203275.6
12	Заг	11884.9	191937.7

13	Бууцагаан	12398.1	184333.8
	<b>Дүн</b>	<b>71157.5</b>	<b>2556369.9</b>

Дөрөв. 2013 оны төсвийн орлогын нэмэгдүүлсэн 319592,4 мянган төгрөгийг дараах байдлаар хуваарилсугай.

№	Арга хэмжээ, ажлын нэр	Мөнгөн дүн
1	Сум бүрт нэг загвар хоршоо байгуулж, хоршооны туршлагыг дэлгэрүүлэх	12,000.0
2	Монгол улсын Мэргэшсэн нягтлан бодогчдын улсын аварга шалгаруулах спортын арга хэмжээг Баянхонгор аймагт зохион байгуулахтай холбоотой зардал	6,000.0
3	Аймгийн танилцуулга ном	25,000.0
4	Аймгийн гадаад, дотоод арга хэмжээ, судалгааны зардал	80,000.0
5	Аймаг, сумдын тухай “Миний нутаг сайхан” баримтат кино хийлгэх зардал	9,500.0
6	Татварын албаны байран дахь хувь хүний 1 өрөөг худалдаж авах зардал	20,000.0
7	Сангийн яамнаас 2007 оны авлагат санхүүгийн дэмжлэгээс суутгасан	58,511.0
8	“Зочин багш-2013” арга хэмжээний зардал	7,337.0
9	Олон нийтийн цагдаагийн хувцас, хэрэгсэл	22,744.4
10	Орон нутгийн өмчит “Баянхонгор NEWMINING” ХХК -ны эхлэлтийн хөрөнгө, үйл ажиллагааны зардал	10,000.0
11	Аймгийн хэвлэл, мэдээллийн зардал	2,500.0
12	Аймгийн Аудитын газрын авто машин/ фургон/	20,000.0
13	Аймгийн 10 дугаар цэцэрлэгийн барилгын буулгалтын зардал	20,000.0
14	Баянхонгор сумын гэр хорооллын ундны усны асуудлыг шийдвэрлэх	26,000.0

Тав. Аймгийн ОНХСанд төвлөрсөн ЖДҮ-ийн зээлийн эргэн төлбөрийн орлого 33000.0 мянган төгрөгийг дараах байдлаар хуваарилсугай.

Заг сумын эмнэлгийн халаалтын зуух солих

ажиллагааны зардал

1000.0 мянга

Баянхонгор сумын 2 дугаар багийн

АЦДШ-ын өргөтгөлийн ажил

32000.0 мянга

Зургаа. Байгаль хамгаалах сангийн зарцуулагдаагүй үлдэгдэл 22500.0 мянган төгрөгийг Байгаль орчны газрын Ангийн менежментийн ерөнхий төлөвлөгөө хийлгэхэд хуваарилсугай.

ДАРГА

Д.ШИРМЭН



## БАЯНХОНГОР АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2013 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 7/3

Номгон

### Ажлын тайлангийн тухай

Аймгийн Аудитын газрын 2013 оны үйл ажиллагааны тухай аймгийн Ерөнхий аудитор Ё.Сугаррагчаагийн илтгэлийг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Аймгийн Аудитын газар 2013 онд төрийн аудитын тухай хуулинд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж, улсын төвлөрсөн болон орон нутгийн төвстөөс санхүүждэг 140 байгууллага, орон нутгийн өмчит 2 аж ахуйн нэгж, 4 тусгай сан, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн салбаруудын нэгдсэн тайлан, Орон нутгийн нэгдсэн төсвийн 2013 оны жилийн эцсийн тайланд санхүүгийн аудит хийж баталгаажуулсан, 21 гүйцэтгэлийн ауйт хийж дүгнэлт, зөвлөмж өгсөн байна.

Санхүүгийн тайлангийн боолон гүйцэтгэлийн аудитаар 273,3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, 543,2 сая төгрөгийн зөрчлийг арилга албан шаардлага өгч 2013 оны 12 дугаар сарын 25-ны байдлаар актын 97,1 хувь, албан шаардлагын 98,2 хувийг барагдуулан, орон нутгийн төсөв болон тусгай сангуудад 393,2 сая төгрөг оруулжээ.

Аудитын дүнд үндэслэн төсвийн хууль тогтоомжийг зөрчиж, албан үүргээ бүрэн биелүүлээгүй 17 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах, 2014 оны орон нутгийн төсвийн орлогыг 378,2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, зардлыг 300,0 сая төгрөгөөр хямдруулж, үр ашгийг дээшлүүлэх саналыг холбогдох байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлсэн байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит хуралдаанаа ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Аудитын газраас 2013 онд хийж гүйцэтгэсэн ажлыг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

Хоёр. Аймгийн Засаг дарга /Д:Жаргалсайхан/-д даалгах нь:

1. Аймгийн Аудитын газраас өгсөн дүгнэлт, зөвлөмж, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, арвилан хэмнэх, орлого нэмэгдүүлэх, зардал хямдруулах талаар тавьсан саналыг эхрэгжүүлж, төсвийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулж, төсвийн

хуультогтоомжийн хэрэгжилтэнд тавих хяналтыг чангатгаж ажилласугай.

2. Аудитын байгууллагын дүгнэлтээр хязгаарлалттай дүгнэлт авсан төсөвт байгууллагуудын менежер, нягтлан бодогч нарт хариуцлага тооцож, үр дүнг аймгийн ИТХ-ын 2014 оны хагас жилийн хуралдаанд мэдээлж ажилласугай.

ДАРГА

Д.ШИРМЭН



## БАЯНХОНГОР АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2013 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 7/4

Номгон

### **Хяналт шалгалтын мөрөөр зохиох ажлыг сайжруулах тухай**

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2012-2013 оны хяналт шалгалтын үйл ажиллагааны тайлан мэдээллийг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Тус байгууллага нь тайлант хугацаанд давхардсан тоогоор 2557 байгууллага, аж ахуйн нэгж, 7905 иргэнийг хамруулан хяналт шалгалт хийж, 8986 зөрчил илрүүлэн 91 хувийг арилгуулсан байна. Нийт 441,6 мянган төгрөгийн нөхөн төлбөр тогтоон аймгийн төсөвт төвлөрүүлж, барагдуулалт 100 хувьтай байна.

Мөн хяналт шалгалтын үр дүн, байгууллагынхаа үйл ажиллагаа болон цаг үеийн тулгамдсан асуудлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, сэрэмжлүүлэх үйл ажиллагааг тогтмолжуулж ажиллажээ.

Аймгийн ИТХ-ын YII хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2012-2013 оны үйл ажиллагааг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

Хоёр. Аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгах нь:

- 2.1. Аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг шалгалтыг жилд хоёроос доошгүй суманд зохион байгуулах арга хэмжээ авсугай.
- 2.2. Байгууллагуудын ерөнхий менежер, бүртгэл тооцооны ажилтны сахилга хариуцлага, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалтыг сайжруулахад дотоодын хяналтыг чиглүүлэн ажилласугай.
- 2.3. Хуралдааны үеэр хурлын төлөөлөгчдөөс гарсан санал шүүмжлэлийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлуулсугай.
- 2.4. Аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Аудитын газрын ажлын тайлангуудад дүгнэлт хийж төсвийг хуулийн дагуу төлөвлөх, үр ашигтай зарцуулах, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх бодлогыг оновчтой төлөвлөн, Төсвийн байгууллагуудын нягтлан бодогчдыг шилжүүлэн ажиллуулах журмыг боловсруулан мөрдөж ажилласугай.

Гурав. Тогтоолын биелэлтэд байнга хяналт тавьж, хэрэгжилтийг хагас бүтэн жилээр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ШИРМЭН



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 7/5

Номгон

**Тайлангийн тухай**

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс 2013 онд хийсэн ажлын тайлангийн тухай илтгэлийг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ НЬ:

Тайлант хугацаанд аймгийн ИТХ-ын хуралдааныг 4 удаа хийж нийт 9 асуудал хэлэлцэн 9 тогтоол, Тэргүүлэгчдийн хуралдааныг 24 удаа хийж нийт 183 асуудлыг хэлэлцэж 159 шийдвэр гаргаснаас гол гол шийдвэрүүдийг дурдвал:

Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай, Төсөвт тодотгол хийх тухай, Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн явц, үр дүн, цаашид авах арга хэмжээний тухай, Нийгмийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр батлах тухай, Аж ахуйн, нэгж байгууллагыг камержуулах, Орон нутгийн өмчит компани байгуулах тухай, Цахим–Архив Баянхонгор дэд хөтөлбөр батлах тухай, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажиллах журам батлах тухай, Рашаан ашигласны төлбөр тогтоох тухай, Монгол бичиг дэд хөтөлбөр батлах тухай, Орон нутгийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих журам батлах тухай, Авьяас дэд хөтөлбөр батлах тухай, Усан хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай, Аймгийн ИТХ-д төрийн байгууллагууд үйл ажиллагаагаа тайлагнах журам батлах тухай, Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын жагсаалт батлах тухай, Шаргалжуут рашаан сувиллын талаар авах арга хэмжээний тухай, Иргэний танхимын ажиллах журам батлах тухай, Иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил тогтоох тухай, аймгийн 2013 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай зэрэг болно.

Аймгийн ИТХ, түүний Тэргүүлэгчдээс бодлого тодорхойлох, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх талаар олон чухал арга хэмжээг авч хэрэгжүүлсэн боловч хурлын байгууллагаас гарсан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх ажил хангалтгүй байсаар байгаа нь хурлын байгууллага, эрх бүхий албан тушаалтнаас гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилтэнд хяналт тавьж, онцгой анхаарч ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.



Аймгийн ИТХ-ын ээлжит ҮII хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн ИТХ, түүний Тэргүүлэгчдээс 2013 онд зохион байгуулсан ажил, үйл ажиллагааг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

Хоёр. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд даалгаж, сумдын ИТХ-д зөвлөх нь:

1. Бүх шатны ИТХ-аас бүрэн эрхийнхээ хугацаанд хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн зорилтоо дүгнэн, гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилтэд онцгой анхаарч, аймаг, сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг хангуулж ажилласугай.
2. Хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг хангах үүрэг бүхий хурлын хороодын ажлыг тогтмолжуулж, төлөөлөгчдийг идэвхижүүлж ажиллахад анхаарсугай.

Гурав. Аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгах нь:

1. Аймгийн ИТХ, түүний Тэргүүлэгчдээс батлан гаргаж буй тогтоол шийдвэрүүдийг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч, биелэлтийг хугацаанд нь мэдээлж ажилласугай.
2. Аймгийн хэмжээнд батлагдан мөрдөгдөж байгаа болон батлуулахаар төслөөр боловсруулагдаж буй хөтөлбөрүүдийг нийгмийн салбар бүрээр нь нэгтгэн иргэдээр хэлэлцүүлэн, аймаг орон нутгийн онцлогт тохирсон, хэрэгжих үндэслэлтэй, санхүүгийн эх үүсвэртэйгээр боловсруулж 2014 оны хоёрдугаар улиралд багтаан батлуулсугай.

Дөрөв. Нутгийн өөрөө удирдах байгууллагууд болон нутгийн захиргааны байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулж ажиллахыг бүх шатны төрийн байгууллагуудын удирдлагуудад анхааруулсугай.

ДАРГА

Д.ШИРМЭН



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 171

Номгон

**Тайлангийн тухай**

“Чандмань - Баянхонгор” ХК-ний ТУЗ-ийн тайланг хэлэлцээд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. “Чандмань-Баянхонгор” ХК-ний 2013 оны ажлын тайланг хэлэлцээд “ХАНГАЛТТАЙ” гэж дүгнэсүгэй.

Хоёр. “Чандмань-Баянхонгор” ХК-ний ТУЗ-ийн дарга /Ж.Дулмаа/-д даалгах нь:

1. “Чандмань-Баянхонгор” ХК-ний дунд хугацааны бизнес төлөвлөгөө болон стратеги төлөвлөгөөг боловсруулан, зээлийн эргэн төлөлтийг хэрхэн зохион байгуулах санал, байгууллагын цаашдын хөгжлийн бодлого, эдийн засгийн үр ашгийн тооцоог нарийвчлан боловсруулж ажилласугай.
2. “Чандмань-Баянхонгор” ХК-ний хувьцаа эзэмшигчдийн асуудлаар холбогдох мэргэжлийн байгууллагуудаас зөвлөгөө авч, компаний журам, дүрмийг боловсронгуй болгох асуудлыг судлан аймгийн ИТХ-ын хуралдаанд 2014 оны эхний хагас жилд багтаан хэлэлцүүлсүгэй.

Гурав. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д даалгасугай.

ДАРГА

Д.ШИРМЭН



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 172

Номгон

**Ажлын хэсэг томилох тухай**

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Ламын гэгээний түмэн өлзий гийсний 375 жилийн ой, Ламын гэгээний наймдугаар дүр Данзанжамбалчойжишинэнг ширээнд нь залах хүндэтгэлийн арга хэмжээний хандив, хөрөнгийг төвлөрүүлэх ажлын хэсгийн ахлагчаар “Ламын гэгээн-нийгмийн хөгжил” сангийн гүйцэтгэх захирал Ж.Хүрэлбаатарыг томилсугай.

Хоёр. Ойн үеэр зохион байгуулагдах хурдан морины уралдаан, үндэсний бөхийн барилдаан, сурын харвааны наадмуудыг аймгийн холбогдох чиглэлийн мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх нь зүйтэй гэж үзсүгэй.

Гурав. Ойн үеэр зохион байгуулагдах уралдаан, тэмцээнүүдийг эртнээс сайтар төлөвлөж, шагналын санг бүрдүүлэх болон бусад холбогдох арга хэмжээг зохион байгуулалтын өндөр түвшинд бэлтгэн явуулахыг аймгийн Морин спорт уяачдын холбоо /Д.Мөнх-Эрдэнэ/, Үндэсний бөхийн холбоо /Д.Мөнхсайхан/, Сурын холбоо /П.Пүрэв/ нарт тус тус даалгасугай.

Дөрөв. Ой зохион байгуулах комиссын ажлын төлөвлөгөөг нарийвчлан гаргаж, арга зүйн удирдлагаар ханган, ажлын явцын талаар ой зохион байгуулах комисст тогтмол мэдээлж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгасугай.

ДАРГА

Д.ШИРМЭН

**МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ,  
ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИАС**

/Шинэчилсэн найруулга/

**ТАВДУГААР БҮЛЭГ:**

**Ажлын алба, Засаг даргаас бусад байгууллагатай харилцах**

**33 дугаар зүйл. Засаг даргын ажлын алба**

33.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын ажлын алба нь Тамгын газар байх бөгөөд дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

33.1.4. хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох;

**36 дугаар зүйл. Хурал, Тэргүүлэгчидтэй харилцах**

36.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийнхээ Хурал, түүний Тэргүүлэгчидтэй дор дурдсан журмаар харилцана:

36.1.1. Хурал, түүний Тэргүүлэгчдээс хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж дүнг тайлагнах;

36.1.2. хууль тогтоомж, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, түүний үр дүнг жил тутам Хуралд тайлагнах;

**39 дүгээр зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын шийдвэрийг биелүүлэх**

39.1. Хурал, Засаг даргаас хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан шийдвэр тухайн нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөх бөгөөд түүнийг холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэд заавал биелүүлнэ.

39.2. Хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд Хурал, Засаг даргаас гаргасан шийдвэрийг биелүүлээгүйгээс учирсан хохирлыг гэм буруутай этгээд бүрэн хэмжээгээр нөхөн төлнө.